



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Газрын харилцааны талаар 2017 онд
баримтлах үйл ажиллагааны
чиглэл батлах тухай

Монгол Улсын "Газрын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.1.2, "Хот байгуулалтын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасныг үндэслэн, аймгийн хэмжээнд Газрын харилцааны талаар 2016 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн тухай аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Газрын харилцааны талаар 2017 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр хавсралтын ёсоор, аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээг хоёрдугаар хавсралтын ёсоор, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Тогтоолын биелэлтийн явцыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хагас жилээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд бүтэн жилээр тайлагнахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА

